

“А.ЭЙНШТЕЙН НЭЭЛТҮҮД- 100 ЖИЛ” ОЙГ МОНГОЛД ТЭМДЭГЛЭХИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Академич Б.Чадраа

Шинжлэх Ухааны Академи

“Дэлхийн физикийн жил-2005”-ийг тэмдэглэх үйл ажиллагааны нээлт болон “Эйнштейний аугаа нээлтүүд-100 жил ” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын үйл ажиллагаанд оролцогч та бүгдэд мэнд дэвшүүлж олдсон завшааныг ашиглан зарим нэгэн санал бодлоо та бүгдтэй хуваалцъя.

Энэ хурал дээр Альберт Эйнштейний онол физикийн салбаруудад яаж нөлөөлсөн, ялангуяа монголын физикийн шинжлэх ухааны салбаруудад яаж хэрэглэгдэн нэвтэрч байгааг манай нэртэй физикчид ярих учраас миний бие дэлхийн физикийн жилийг, Эйнштейний аугаа их нээлтүүдийг Монголд тэмдэглэхийн учир холбогдлын асуудлаар өөрийн ойлголт, санал бодлоо ярья.

А.Эйнштейн бодисын өөр өөр төлөв байдалд орших масс жинтэй эгэл бөөмс, массгүй цацраг хоёр харилцан бие биедээ шилжиж болдог, тодорхой масстай эгэл бөөмс тохирсон эквивалент энергийг агуулж байдаг гэдгийг тогтоосон нь хүн төрөлхтөний ертөнцийг үзэх үзэлд хувьсгал хийсэн юм. Үүний ч ач нөлөөгөөр хүмүүсийн сэтгэх цар хүрээ өргөжин тэлж атомын цөмөөс, сансрын уудмыг хүртэлх орон зайг эзэмжиж, үйл ажиллагаагаа явуулах боллоо.

Маргааш монгол хүн сансарт ниссэн, Монголын физикчид өөрсдийн оюун ухаан, гараараа бүтээсэн багаж төхөөрөмжийг сансарт хөөргөсний ойг тэмдэглэх гэж байгаа нь бас л учир утгатай, үүнтэй ч холбоотой.

Аливаа улс орон хөгжиж, дэвжигэвэл мэдлэгт суурилсан эдийн засагтай, шинжлэх ухаанд суурилсан нийгэмтэй болохыг зорих хэрэгтэй бөгөөд өөр ямарч хувилбар байхгүй гэдгийг дэлхий ертөнц даган мөрдөж байгаа өнөө үед их ойнуудыг тэмдэглэх нь Монголын олон түмнийг үүн лүү чиглүүлэх, гэгээрүүлэх, энэ үзэл бодлыг Монголд нэвтрүүлэхэд туслах их ач холбогдолтой гэж бодож байна.

Бас нэгэн зүйлийг хэлэхэд энэ их ойг тэмдэглэх нь Монголын залуу физикчдийг

бэлтгэх, хойч үеэ бий болгоход нэн ач холбогдолтой.

Физикчид бол сэтгэхүйн дээд мандалд оршиж, сэтгэж, бясалгаж байдаг хүмүүс болохын хувьд аливаа үйл ажиллагааг явуулахдаа ертөнцийн хэмжээнд, макро, микро түвшинд бодож байж, монголынхоо хөрс шороонд буулгадагаараа, бүх л зүйлийг байгалийн харилцан үйлчлэлийн нэгдсэн онолд тулгуурлан, түүнд тохируулан хийдгээрээ онцлогтой. Агуулгыг нь амьдралд илүү зохицуулан авдаг учир үр дүн нь ч тодорхой байдаг. Ийм ч учраас физикчдийг бусдаас илүү бүтээлч, ихийг сэтгэдэг хүмүүс гэж үздэг.

Нөгөө талаар зах зээлийн өөрөөр хэлбэл орчин үеийн физикч хүн гэж танд юу хэрэгтэй болохоо сэтгэн олж чаддаг, түүнийгээ хийх аргаа өөрөө олдог, хэрэгжүүлж чаддаг хүнийг хэлдэг. Иймээс бид бусдаас илүү бүтээлч хүмүүс юм. Энэ үзэл бодлыг бүх дэлхийн физикчид баримталдаг.

Ер нь боловсрол шинжлэх ухаан бол үнэхээрийн юутай ч зүйрлэшгүй чухал үнэт баялаг, үүний дотор физик, математик тэргүүн байранд орно.

Бид микро ертөнцийн түвшний боловсролыг эзэмшиж байж макро ертөнцийг илүү эзэмшиж чадна. Өнөө үеийнхэн үүнд илүү анхаарал тавих шаардлагатай. Бүх төрлийн сургуулиудын боловсролын хөтөлбөрийг боловсруулахдаа ч үүнийг анхаарвал зохино.

Боловсрол, шинжлэх ухаан нь агуу их үнэтэй, шийдвэрлэгч баялаг болохын нэг жишээ нь байгалийн ямарч түүхий эд байхгүй орон гэж хэлж болохоор өмнөд Солонгос улсын хөгжил хориодхон жилийн өмнө өнөөгийн Монголын түвшинд байсан. Одоо бүх хүмүүстээ өндөр боловсрол, шинжлэх ухааныг эзэмшүүлж, оюуны үйлдвэрлэлийг эрхлээд дэлхийд хөгжлөөрөө 11 дүгээр байранд орж, ойрын үед эхний 10 орны тоонд шилжих гэж байна. Энэ нь боловсрол, шинжлэх ухааны мэдлэг гэдэг бол юугаараа ч, юутай ч зэрэгцүүлж болзошгүй, шавхагдашгүй үнэт баялаг болохыг баталж буй ажээ.

Газрын дээрх доорх баялаг бол өнөөгийнх шиг хэлбэрээр ашиглавал хойшид шүтэх, бишрэх, мөрөөдөх баялаг огт биш, улс орныг олон жил тогтвортой, тууштай хөгжүүлэх чиглэл ч биш гэж боддог.

Ер нь аливаа асуудлыг авч үзэхдээ макро ойлголтыг микротой нь хамт авч үзсэн тохиолдолд л үнэн бодит шийдэлд хүрч, тэр нь хэрэгжихээрээ үр дүнтэй болдог. Ялангуяа манай өнөөгийн нөхцөлд өнгөц, хийсвэр, гадаргуугийн ойлголтоор, сэтгэлийн хөөрлөөр хөгжлийн асуудлыг шийдэх гэж оролддог зүйлс олон гарч байгаа нь цөөхөн монголчуудыг ядууралд хүргэж, ажил төрөлгүй, хүмүүсийг залхуу болгож байна. .

Ядуу амьдрал бол залхуурсны чинь төлөө олгож байгаа шагнал мөөн гэдгийг хүн бүрд ойлгуулах хэрэгтэй.

Эцсийн бүлэгт Монголын төр нь ард иргэддээ ийм шагнал олгож байна. Бүх хүмүүсийг ажилч хичээнгүй болгох арга хэмжээ авах шаардлагатай байна. Ингэж чадсан тэр өдөр л бид цэнгэлийн манлай руу тэмүүлнэ. Физикчид бид энэ чиглэлээр их хувь хандив оруулж, хошуучилж чадна.

Сайн сайхан бүхнийг хүсье.

2005 оны 03 дугаар сарын 21

---ooOoo---